



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 116 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 281,257,700.00 (хоёр зуун наян нэгэн сая хоёр зуун тавин долоон мянга долоон зуу) төгрөгийн балансын үнэтэй, 4,938,088.32 (дөрвөн сая есөн зуун гучин найман мянга наян найман төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга А.Дагвадорж, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга Б.Ичинхорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Хавсралтад заасан орон сууц, автомашины гаражид хяналтын хэмжилт хийлгэж, шаардлагатай тохиолдолд үнэлгээнд залруулга хийх ажлыг зохион байгуулах;

2.2 Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нэр дээрх үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг хүчингүй болгож, “Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр бүртгүүлэх;

2.3.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.5. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 132
дугаар тогтоолын хавсралт



**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын балансаас Дипломат байгууллагын үйлчилгээг
эрхлэх газар ТӨҮГ-ын балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт**

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Орон сууц (Роял Грийн вилла хотхоны 62/8 дугаар байрны Б1-103 тоотод байрлах 150 м2 талбай бүхий орон сууц	2019	ш	1	249,487,540.00	249,487,540.00	4,301,509.32	245,186,030.68
2	Автомашинны зогсоол /62/8 дугаар байрны зоорийн 2 тоот, Г62/10 байрны 59 тоот/	2019	ш	2	12,731,580.00	25,463,160.00	636,579.00	24,826,581.00
3	Ерөнхийлөгчийн өрөөний тавилга	2018	ком	1	6,307,000.00	6,307,000.00		6,307,000.00
						281,257,700.00	4,938,088.32	276,319,611.68
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			3 (гурав)		281,257,700.00 (хоёр зуун наян нэгэн сая хоёр зуун тавин долоон мянга долоон зуу)	4,938,088.32 (дөрвөн сая есөн зуун гучин найман мянга наян найман төгрөг гучин хоёр мөнгө)	276,319,611.68 (хоёр зуун далан зургаан сая гурван зуун арван есөн мянга зургаан зуун арван нэгэн төгрөг жаран найман мөнгө)